



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 9 дүгээр
сарын 21-ний өдөр


Дугаар 97

Улаанбаатар
хот

Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16.2, 17.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гамшгаас хамгаалах улсын албад, тэдгээрийн түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага, албадын дарга нарыг хавсралт ёсоор баталсугай.
2. Гамшгаас хамгаалах улсын албадын бүрэлдэхүүнийг томилон тэдгээрийн гүйцэтгэх үүргийг тогтоож, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг улсын албадын дарга нарт, улсын албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхэд тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай" Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 81 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын Шадар сайд

У.ХҮРЭЛСҮХ



Засгийн газрын 2016 оны 97 дугаар
тогтоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАД

№	Улсын албаны нэр	Түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага	Улсын албаны дарга
1	Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба	Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
2	Барилга, хот байгуулалтын алба	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Барилга, хот байгуулалтын сайд
3	Зам, тээврийн алба	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Зам, тээврийн хөгжлийн сайд
4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн алба	Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
5	Хүн ам, нийгмийн хамгааллын алба	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
6	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
7	Түлш, эрчим хүчний алба	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Эрчим хүчний сайд
8	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Эрүүл мэндийн сайд
9	Мэдээлэл, харилцаа холбооны алба	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга
10	Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба	Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга

11	Хэв журам сахиулах алба	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	Цагдаагийн ерөнхий газрын дарга
12	Сурталчилгааны алба	-	Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга